

ТАНИЛЦУУЛГА

*Журам батлах тухай Хөдөлмөр, нийгмийн
хамгааллын сайдын тушаалын төсөл
боловсруулсан тухай*

Улсын Их Хурлын чуулганы 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар Нийгмийн даатгалын ерөнхий хууль /шинэчилсэн найруулга/-ийг хэлэлцэн баталсан.

Нийгмийн даатгалын ерөнхий хууль /шинэчилсэн найруулга/-ийн 17 дугаар зүйлийн 17.4 дэх хэсэгт “Мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэх, хадгалах, ашиглах, мэдээлэлд хяналт тавих, нууцлал, аюулгүй байдлыг хангах журмыг хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална” гэж, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн 16 дугаар зүйлийн 16.4 дэх хэсэгт “Мэдээллийн санг бүрдүүлэх, боловсруулах, түгээх, ашиглах, хянах, хадгалах, хамгаалах журмыг хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална” тус тус заасан.

Хуулийн дээрх заалтыг хэрэгжүүлэх зорилгоор “Журам батлах тухай” Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын тушаалын болон журмын төслийг боловсруулав.

Журмын төсөлд нийгмийн даатгалын мэдээллийн нэгдсэн сангийн болон үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын мэдээллийн сангийн бүрдүүлэлт, хадгалах, ашиглах зохицуулалт, мэдээлэлд хяналт тавих эрх бүхий этгээд, нууцлал, аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаа, мэдээллийн нэгдсэн сангаас даатгуулагч, иргэн, ажил олгогчдод нийгмийн даатгалын үйлчилгээ үзүүлэх зэрэг харилцааг тусгасан болно.

Энэхүү тушаалын төсөл батлагдсанаар нийгмийн даатгалын сангийн болон улсын төсвөөс нэмэлт хөрөнгө шаардагдахгүй.

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ